



Монгол Улсын  
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**

Даргын зөвлөлийн хуралдаанд

**АВЛИГЫН ИНДЕКСИЙГ БУУРУУЛАХ ЗОРИЛГО БҮХИЙ  
АЖЛЫН ХЭСГИЙН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРЧИМЖҮҮЛСЭН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

Захиргаа, удирдлагын хэлтэс

2022 оны 06 дугаар сарын 29



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2021 оны 7 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар  
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Авлигын индексийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсгийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
2. Авлига, хүнд суртлыг таслан зогсоох замаар авлигын индексийг бууруулах эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Х.Нямбаатар)-т даалгасугай.
3. Шаардлагатай тохиолдолд Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын дэд хэсгийг байгуулах арга хэмжээ авах, авч хэрэгжүүлсэн ажлын тайлангаа тухай бүр нь Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Ажлын хэсэг (Х.Нямбаатар)-т даалгасугай.
4. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Ажлын хэсэг байгуулах тухай" Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 69 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ерөнхий сайдын 2021 оны 120 дугаар  
захирамжийн хавсралт

### АВЛИГЫН ИНДЕКСИЙГ БУУРУУЛАХ ЗОРИЛГО БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Гишүүд: -Санхүүгийн зохицуулах хорооны дарга (зөвшилцсөнөөр);  
-Улсын ерөнхий прокурорын орлогч (зөвшилцсөнөөр);  
-Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр);  
-Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);  
-Авлигатай тэмцэх газрын дэд дарга (зөвшилцсөнөөр);  
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;  
-Ерөнхий сайдын ахлах зөвлөх;  
-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  
-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга;  
-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;  
-Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;  
-Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;  
-Эрүүгийн цагдаагийн албаны дарга;  
-Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга;  
-Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга.
- Нарийн бичгийн дарга: -Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга.



Б А Т Л А В  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
Л.ОЮУН-ЭРДЭНЭ  
2021 оны 8. дугаар сарын 17

ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ БАЙГУУЛЛАГААС ГАРГАДАГ АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН  
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (ИНДЕКС)-ИЙГ БУУРУУЛАХ ЗОРИЛГО БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЭРЧИМЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 08 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх үр дүн
<b>1.ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХҮРЭЭНД:</b>					
1	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийтийн мэдээллийн тухай, Хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах	2021	Хууль зүй, дотоод хэргийн яам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Иргэний мэдэх эрхийг баталгаажуулах, төрийн байгууллагын үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд ойртуулах, үйл ажиллагааны түргэн шуурхай, ил тод байдлыг хангах, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох боломжийг сайжруулах замаар авлига, хүнд суртлыг бууруулах эрх зүйн орчин бүрдэнэ.
2	Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2021	Хууль зүй, дотоод хэргийн яам	Авлигатай тэмцэх газар	Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх

НИЙТ:

4 бүлэг,

48 арга хэмжээ.



ТӨБЗГ:

4 бүлэг,

10 арга хэмжээ.





Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰᠠᠳ ᠭᠡᠮᠲᠤ ᠬᠡᠷᠭᠡᠭᠡᠰ ᠤᠷᠦᠳᠴᠢᠯᠠᠨ ᠰᠡᠷᠭᠢᠯᠡᠬᠡ ᠠᠵᠢᠯᠢᠭ ᠵᠢᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠬᠤ ᠵᠥᠪᠯᠡᠯ

  
**МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Бага тойруу, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Засгийн газрын V байр,  
Утас: 260095, Факс: (976-11) 260042

2022.06.09 № 21191  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ЦЭНГЭЛ ТАНАА**

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаар захирамжаар “Транспэрэнси Интернэшнл” Олон Улсын байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт (индекс)-ийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Иймд Ажлын хэсгээс авч хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө (2021-2022)-ний эхний хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлднэ үү.

АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Л.НЯМГЭРЭЛ  


**НИЙТ:**

**4 бүлэг,**

**48 арга хэмжээ.**



**ТӨБЗГ-т  
хамаарах:**

**4 бүлэг,**

**10 арга хэмжээ.**



**Хэрэгжилт, 2022 эхний  
хагас жил:**

Төлөвлөгөөнд тусгагдсан  
холбогдох арга хэмжээ  
(заалт)-ний тоо – **10**; Үүнээс:

100 % - 9 арга хэмжээ;

70 % - 1 арга хэмжээ;

Хэрэгжилтийн дундаж хувь,  
үнэлгээ – **97.0 %**,

**“Тодорхой үр дүнд  
хүрсэн” үнэлгээтэй.**

**Цаашид: Холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг хангахад хэлтэс, албад анхаарч, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах.**

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА.**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,  
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,  
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2022.06.24 № A-1/1340

танай 2022.06.07-ны № 2/191 -Т


МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА Л.НЯМГЭРЭЛ ТАНАА

**Тайлан хүргүүлэх тухай**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаар захирамжаар байгуулагдсан Авлигын индексийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсгээс авч хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайланг 2022 оны эхний хагас жилийн дүнгээр гарган хүргүүлж байна.

Хавсралт <sup>1д</sup> хуудастай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132008450

A-4/2022

ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ БАЙГУУЛЛАГААС ГАРГАДАГ АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (ИНДЕКС)-ИЙГ  
БУУРУУЛАХ ЗОРИЛГО БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРЧИМЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ТУСГАГДСАН ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2022 оны 06 дугаар сарын 23

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц, хувь
<b>1.ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХҮРЭЭНД:</b>						
1	4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	2021	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Төрийн өмчит компани байгуулах үндэслэлийг тодорхой болгох, алдагдалтай ажилласан тохиолдолд хэрхэх, компанийн засаглалыг сайжруулах, төрийг төлөөлөх этгээдийг ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, хяналттай болгох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тусгаж, эрх зүйн орчин боловсронгуй болно.	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд УИХ-д өргөн барихыг дэмжсэн. Уг хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр УИХ-д өргөн барьсан бөгөөд Эдийн засгийн Байнгын хорооны хуралдаанаас УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр дэмжсэн. УИХ-ын 06 дугаар сарын 09-10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэхийг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн байна.  Хэрэгжилт – 100 хувь.
2	5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн	2022	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн	Эрх зүйн орчин боловсронгуй болно.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт

	найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх			зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	<p>материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж байсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барих ажлыг ЗГХЭГ хариуцан ажиллаж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 29 дүгээр тушаалаар уг хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурал 2021 онд 2 удаа зохион байгуулагдаж, хуулийн төслийг хэлэлцсэн бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагын баг оролцож байна. Ажлын хэсгийн саналыг судлан боловсруулах, төсөлд тусгах арга хэмжээ авч, засвар, өөрчлөлтүүдийг оруулж, холбогдох судалгааг шинэчлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/1951 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.</p> <p>2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр ХЗДХЯ-нд уг хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг 2022 оны эхний хагас жилд 5 удаа хуралдаж, хэлэлцүүлгээс гаргасан болон яамд, аймаг, орон нутгаас ирүүлсэн саналыг төсөлд тусган Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулав. Засгийн газрын гишүүдээс хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал</p>
--	--	--	--	--	--



						гаргасан тул Засгийн газрын хуралдаанаас дэмжихийг татгалзаж хойшлуулсан. Хэрэгжилт – 70 хувь.
<b>2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:</b>						
3	4.Төрийн худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтыг боловсронгуй буюу 2-way болгох арга хэмжээ авах	2021-2022	Сангийн яам	Төрийн худалдан авах ажиллагааны газар, Тагнуулын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	Төрийн цахим худалдан авах ажиллагаа илүү боловсронгуй, ил тод, шударга, хүртээмжтэй болж, худалдан авалтын процесс, шалгуур, тэнцсэн, хасагдсан гэх зэрэг шийдвэрүүд ил болж, шударга өрсөлдөөнийг дэмжинэ.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангуулах арга хэмжээ аван ажиллаж байна. Энэ хүрээнд ТӨБЗГ-аас төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хариуцан хэрэгжүүлж байгаа 56 хуулийн этгээдийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="https://www.tender.gov.mn">https://www.tender.gov.mn</a> -нд оруулж байгаа байдалд хяналт тавих, төлөвлөгөөг цахим системээр батлах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.  Системийг боловсронгуй болгох асуудлаар тодорхой санал гарган холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа болно. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="https://www.tender.gov.mn">https://www.tender.gov.mn</a> -ийг боловсронгуй болгох техник, технологийн асуудлыг ТӨБЗГ-аас шууд хариуцахгүй болно. Хэрэгжилт – 100 хувь.
<b>3. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ОЛОН НИЙТИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ХҮРЭЭНД:</b>						
4	8.Төрийн байгууллагын	2021-2022	Авлигатай тэмцэх газар	Төрийн албаны	Төрийн албан хаагч эрсдэлээс сэргийлж,	Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдох болзошгүй эрсдэлээс

	<p>авлигад өртөж болзошгүй ажлын байрны судалгааг дахин шинэчилж, төрийн албан хаагчийг эрсдэлээс хамгаалж сэргийлэх арга хэмжээ авах</p>			<p>зөвлөл, яам, агентлаг, байгууллага</p>	<p>шударга ажилладаг нөхцөл бүрдэнэ.</p>	<p>урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын дунд давхар ажил эрхлэлтийн судалгааг 4 дүгээр улиралд авахаар төлөвлөсөн бөгөөд судалгааны дүнд үндэслэн тодорхой арга хэмжээ авахаар ажиллаж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн дагуу 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр нийт албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг тусгасан тусгайлсан хөтөлбөр боловсруулж, холбогдох мэргэжлийн хүмүүс, лекторыг урьж сургалт зохион байгуулсан.</p> <p>Түүнчлэн, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, аргазүйн ажилд ТӨБЗГ-ын албан хаагчид, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын нийт 456 албан хаагчийг хамруулсан байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- сургалтад 121;</li> <li>- мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгт – 228;</li> <li>- хуулийн хугацаа сануулах арга хэмжээнд – 107.</li> </ul> <p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн 19 төрлийн постер, шторк зэрэг урьдчилан</p>
--	---	--	--	---	--	---

						сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны материалыг нийт албан хаагчид, олон нийтэд хүргэх зорилгоор байгууллагын цахим хуудсанд ээлжлүүлэн байршуулж, сурталчлах ажлыг хийж байна. Хэрэгжилт – 100 хувь.
5	9.Төрийн бүх шатны албан тушаалд нэр дэвшигч этгээд нь цахим хэлбэрээр ажилд орох, дэвшин томилогдох хүсэлтээ гаргаж, тухайн ажлын байрны шаардлагыг хангаагүй тохиолдолд мэдүүлэх боломжгүй болгох, мөн хүсэлтийг томилж төрийн байгууллага, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газарт давхар хүргүүлэх тогтолцоог бэхжүүлэх	2021-2022	Авлигатай тэмцэх газар	Төрийн албаны зөвлөл, яам, агентлаг, байгууллага	Төрийн томилгоо зарчим, ур чадвар, мэдлэг үндэслэгдэн хэрэгжинэ.	Уг заалтад дурдсан тогтолцоог холбогдох байгууллагуудаас хариуцан зохион байгуулж, бүрдүүлсэн тохиолдолд цаашид хэрэгжүүлээд ажиллах бүрэн боломжтой. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өөрийн байгууллагын албан тушаал болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хариуцан хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 49 хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилохоор нэр дэвшүүлэх тухай бүрд Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан бүртгэх, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулах ажлыг хэвшүүлсэн. 2022 оны эхний хагас жилд дээр дурдсан албан тушаалын төрлүүдэд нэр дэвшсэн нийт 64 нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын байдлыг хянуулсны үндсэн дээр томилох шийдвэр гаргасан байна. Хэрэгжилт – 100 хувь.
6	10.Ковидын үеийн төрийн албаны томилгоог судлан, шалгаж, хуульд	2021-2022	Төрийн албан зөвлөл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Цагдаагийн	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Ковидын үеийн томилгоотой албан тушаалтан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт байхгүй байна.

	заасан шаардлага, хангаагүй албан тушаалтны томилгоог хүчингүй болгох арга хэмжээ авах			ерөнхий газар, яам, агентлаг, байгууллага		Төрийн албаны зөвлөлөөс зохих журмын дагуу сонгон шалгаруулалтад орж, тэнцсэн 8 нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж ирүүлснийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар томилсон байна. Тайлант хугацаанд Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг шинээр төрийн албан тушаалд томилогдсон 3 албан хаагч өргөсөн. Хэрэгжилт – 100 хувь.
7	11.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилон дэвшүүлдэг тогтолцоонд шилжих	2021-2022	Төрийн албаны зөвлөл	Ерөнхий сайдын ажлын алба, яам, агентлаг, байгууллага	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуур цэгцтэй, шударга болно. Чадварлаг, мэргэшсэн, шударга төрийн албан хаагчийн ажлын байрны баталгаа бий болно.	Тайлант хугацаанд сул орон тоонд дэвшүүлэн томилсон тохиолдол гаргаагүй. Төрийн албаны зөвлөлөөс зохих журмын дагуу сонгон шалгаруулалтад орж, тэнцсэн 8 нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж ирүүлснийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар томилсон байна. Тайлант хугацаанд Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг шинээр төрийн албан тушаалд томилогдсон 3 албан хаагч өргөсөн. Хэрэгжилт – 100 хувь.

8	12.Нийтийн албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмын дагуу томилсон, дэвшүүлсэн эсэхэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн тайланг олон нийтэд жил бүр мэдээлдэг болох	2021-2022	Төрийн албаны зөвлөл	Ерөнхий сайдын ажлын алба, яам, агентлаг	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хариуцлага тооцдог болж, мэдээллийг олон нийт танилцах боломж бүрдэнэ.	Тайлант хугацаанд, Төрийн албаны зөвлөлөөс зохих журмын дагуу сонгон шалгаруулалтад орж, тэнцсэн 8 нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж ирүүлснийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар томилсон байна. Тайлант хугацаанд Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг шинээр төрийн албан тушаалд томилогдсон 3 албан хаагч өргөсөн.  Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо <a href="https://hrm.csc.gov.mn">https://hrm.csc.gov.mn</a> цахим системд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус систем нь төрийн албаны цалингийн нэгдсэн систем <a href="http://payroll.gov.mn">payroll.gov.mn</a> -тэй холбогдсон тул уг системээр дамжуулан холбогдох байгууллагаас хяналт тавьж байгаа. Эдгээр системд төрийн албан хаагчийн мэдээлэл хянагдан баталгааждаг.  Хэрэгжилт – 100 хувь.
<b>4.ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, АВЛИГЫН ХЭРГИЙГ ХЯНАНН ШИЙДВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТӨРД УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ХҮРЭЭНД:</b>						
9	1.Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон худалдан авах	2021-2022	Сангийн яам	Яам, агентлаг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Тагнуулын	Байгууллагын үйл ажиллагаа, тухайн байгууллагаас зохион байгуулсан худалдан авах болон сонгон шалгаруулах ажиллагааны ил тод, нээлттэй байдал	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг аван ажиллаж байна. Энэ хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар



	ажиллагааг ил тод, нээлттэй болгох			ерөнхий газар, байгууллага	хангагдаж, иргэд мэдээлэл олж авах эрх хэрэгжинэ.	<p>сарын 23-ны өдрийн "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 675 дугаар тогтоолоор үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийт танилцах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх, зардлыг багасгаж, хэмнэлтийг бий болгох, ашигт ажиллагаа, орлого, өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинэчлэл хийж ажиллахыг даалгасан байна. Түүнчлэн, 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлуудад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны А-1/947 тоот албан бичгээр чиглэл өгсөн. Эдгээр авсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг тооцох чиглэлээр 2022 оны 3-4 дүгээр улиралд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудын цахим хуудсанд шинжилгээ хийж, нээлттэй, ил тод байдлыг үнэлэхээр төлөвлөж байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцсэн төрийн өмчийн харилцаа, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн асуудлаар гарсан тогтоол, тэмдэглэлийг байгууллагын цахим хуудас <a href="https://pcsp.gov.mn">https://pcsp.gov.mn</a> -д тухай бүр нээлттэй</p>
--	------------------------------------	--	--	----------------------------	---	--

						байршуулж хэвшсэн бөгөөд олон нийтийн зүгээс танилцах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн болно. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 оны эхний хагас жилд төрийн өмчит 56 хуулийн этгээдийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлтүүдийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="https://www.tender.gov.mn">https://www.tender.gov.mn</a> -д оруулах үйл явцад хяналт тавьж, цахим хэлбэрээр хянан баталгаажуулсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт батлагдсан төсөвт тусгагдсан 6 их наяд 98 тэрбум 157 сая төгрөг, тухайн онд санхүүжих 3 их наяд 710 тэрбум, 124 сая төгрөгийн үнийн дүн бүхий нийт 4,376 тендерийг зохион байгуулах төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="https://www.tender.gov.mn">https://www.tender.gov.mn</a> -ээр хянан баталсан байна. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон нийт 19 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг хянан баталж, Сангийн яаманд эцэслэн батлуулахаар илгээсэн. Хэрэгжилт – 100 хувь.
10	Төрийн болон орон нутгийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдалтай тэмцэх, төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга	2021-2022	Улсын ерөнхий прокурорын газар	Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, холбогдох яам, агентлаг, байгууллага	Төрд хохирлын нэгдсэн мэдээллийн болж, төрд хохирлыг этгээдээр учирсан талаар судалгаа, сантай учирсан буруутай шуурхай,	1. 2022 оны 3, 4 дүгээр сард гарсан Монгол Улсын Засгийн газрын 124, 148 дугаар тогтоолын дагуу концессын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, хувьчлах үйл ажиллагааны шийдвэр алдаатай гарсан зэргийн улмаас тухайн үеийн буюу 2014, 2015 оны холбогдох шийдвэрүүдийг хүчингүй болгож, хувьд шилжсэн өмч

	хэмжээ авах, үр дүнг тооцох				бүрэн төлүүлдэг болсон байна.	<p>хөрөнгийг төрийн өмчид буцаан авах ажлыг хийсэн. Энэ хүрээнд, концессын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн концесс эзэмшигч “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд байгуулсан концессын гэрээг цуцалж, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-иас буцаан шилжүүлж авсан.</p> <p>Мөн “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг “Бэйсмент” ХХК-д 2015 онд давуу эрх олгон худалдсан хувьчлалыг хүчингүйд тооцож, “Цемент шохой” ХК-ийн удирдлагын эрх, хөрөнгийг төрд буцаан аваад байна. Төрд буцаан авсан дээрх компаниудын удирдлага, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, үйдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, авлага, өглөг, өр төлбөр, ашиг орлогод санхүүгийн шинжилгээ хийх, хөрөнгийг тоолох, бүртгэх зэрэг ажлуудыг хийж байна. Үүний зэрэгцээ холбогдох хууль, хяналтын байгууллагатай хамтран төрд учирсан хохирлыг тогтооход чиглэсэн арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p>2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран Баянзүрх дүүргийн 6-р хорооны Бөхийн өргөөний хойно байрлах 441 м.кв талбай бүхий анхны холбооны байшин болох төрийн өмчийн барилгыг “Ванхүү” ХХК-ийн хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд</p>
--	-----------------------------	--	--	--	-------------------------------	--

					<p>гаргасан бөгөөд Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хэргийг хянан хэлэлцэж, 101/ШШ2022/02712 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн байна.</p> <p>3. Сангийн сайдын 2022 оны 13-2/886 дугаар албан бичгээр ирүүлсэн “Удирдамж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хариуцан хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн гүйцэтгэх захирал болон төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал нарт албан бичиг (2022 оны А-6/348) хүргүүлж, хууль бус шийдвэрийн улмаас халагдсан ажилтнуудад төрийн өмчит компани, ТӨҮГ-ын төсвөөс олгосон нөхөн олговор, түүнийг холбогдох хуулийн байгууллагын шийдвэрийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн талаарх судалгааг авч, нэгтгэн боловсруулсан. Нийт 48 хуулийн этгээдийг хамруулсан судалгааны дүнгээр 2.18 тэрбум төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс 67.66 сая төгрөгийг хуулийн байгууллагын шийдвэрээр буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн байна.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь.</p>
--	--	--	--	--	---

### ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Ерөнхий сайдын 2021 оны 120 дугаар захирамжаар байгуулагдсан “Авлигын индексийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсэг”-ийн авч хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний 4 бүлгийн хүрээнд тусгагдсан холбогдох 10 арга хэмжээний биелэлтийг тайлагнав.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн үйл ажиллагаа болон төрийн захиргааны байгууллагын нийтлэг үүрэгтэй холбоотой тусгагдсан эдгээр 10 арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаартай тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалаар үнэлсэн болно.

**Үнэлгээний дүнгийн товч танилцуулга (2022 оны эхний хагас жилийн дүнгээр):**

Төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээ (заалт)-ний тоо – 10; Үүнээс:

100 % - 9 арга хэмжээ;

70 % - 1 арга хэмжээ;

Хэрэгжилтийн дундаж хувь, үнэлгээ – 97.0 %, “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ